



ЭРДЭНЭС-ТАВАН ТОЛГОЙ ХК-Д

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ

**ШУДАРГА ӨРСӨЛДӨӨН,  
ХЭРЭГЛЭГЧИЙН ТӨЛӨӨ ГАЗАР**

15141 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Ж.Самбуугийн гудамж, Засгийн газрын XI байр,  
Утас: 26 26 53, Факс: (976-11) 32 00 41,  
И-мэйл: contact@afccp.gov.mn, Вэбсайт: www.afccp.gov.mn

2020. 03. 02 № 1/257  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Тендер шалгаруулалтын тухай**

Танай компаниас зарласан "Даатгалын үйлчилгээ үзүүлэгчийг сонгон шалгаруулах" ЭТТ/202001065 дугаартай тендер шалгаруулалтын баримт бичигт холбогдох гомдлыг "Мөнх даатгал" ХХК-иас тус газарт ирүүлсний дагуу Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу хянаж байна.

Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 55.4-т заасны дагуу гомдлыг хянан хэлэлцэж шийдвэрлэх хүртэлх хугацаанд уг тендерийн баримт бичгийн шалгаруулалттай холбогдуулан гаргасан захиалагчийн шийдвэр буюу үйлдлийн хэрэгжилтийг, тендер шалгаруулалтын материал авах, нээлт хийх үйл ажиллагааг түр түдгэлзүүлж байгааг үүгээр мэдэгдэж байна.

Уг тендер шалгаруулалттай холбоотой холбогдох тайлбар, үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл болон бусад баримт материалыг 2020 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

ДАРГА

Б.ЛХАГВА

0000888